

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 3-Р УЛИРЛЫН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ХИЙЖ ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

2022.12.16

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь
Хэрэгжилт хангалтгүй дараах арга хэмжээнүүд байна			
1	Хүүхдийн төлөө зөвлөлийн 2022 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулах гэсэн заалт 3 улирал дараалан хангалтгүй хэрэгжиж байгаа тул хариуцсан хэлтэс болон агентлагийн тухайн асуудлыг хариуцсан албан хаагчид анхааралдаа авч ажиллах шаардлагатай байна.	НБХ	
2	Аймгийн Засаг даргын 2022 оны 255 дугаар захирамжаар БШУГ-ын бүтэц орон тоо батлагдсантай холбогдуулан төрийн захиргааны 18 албан тушаалын тодорхойлолтыг төрийн албаны зөвлөлөөр батлуулах ажил БШУЯ-аас нэгдсэн журмаар аймгуудын БШУГ-ын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг батлуулах тул 2 улирал дараалан удаашралтай байна.	Аймгийн Засаг даргын 2022 оны 255 дугаар захирамжаар БШУГ-ын бүтэц орон тоо батлагдсантай холбогдуулан төрийн захиргааны 18 албан тушаалын тодорхойлолтыг төрийн албаны зөвлөлөөр хянуулахаар 2022 оны 7 сарын 20-ны өдөр хүргүүлсэн. Гэвч аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс БШУЯ -наас хариуцаж батлуулахаар болсон гэсэн шийдвэрийн дагуу бүрдүүлэн хүргүүлсэн материалыг 9 дүгээр сард буцаан БШУГ-т хүргүүлээд байна. БШУЯ-наас шинээр бий болсон 9 албан тушаалд тавигдах шаардлагыг боловсруулан, аймгийн төрийн албаны зөвлөлөөр хянуулан батлуулах чиглэлэийг өгөөд байна.БШУГ бүтэц, журмын дагуу албан тушаалын тодорхойлолтуудыг боловсруулаад байна.	70
3	Ажлын байран дээрх сэтгэл зүйн эрүүл мэндийн талаар удирдамж, чиглэл батлах тухай А/298 тоот захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж удирдлага арга зүйгээр хангаж, тайлан мэдээг нэгтгэн тайлагнах	ТЗУХ	
4	“Хандлагаа өөрчилъе-Хамтдаа хөгжье” аян зохион байгуулах тухай А/299 тоот захирамжийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэст даалгасан боловч хяналт тавьж ажиллагаагүй байна.	ТЗУХ	
5	Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 84535 үхэр	ХБТХОХ, МЭГ	

	хамруулахаас 42269 үхэр буюу хамрагдвал зохих үхрийн 50 хувийг хамруулсан байгаа тул холбогдох хэлтэс, агентлаг анхаарч ажиллах.		
6	Ерөнхий боловсролын сургуулиудад хадгалагдаж байгаа чанарын шаардлага хангахгүй болсон химийн бодис, урвалжийг шилжүүлж, устгуулах үйл ажиллагааг яаралтай зохион байгуулах.	Дундговь аймгийн хэмжээнд Сайнцагаан, Эрдэнэдалай, Дэлгэрхангай, Говь угтаал, Хулд, Луус сумдын Ерөнхий боловсролын сургуулиудад хадгалагдаж байсан чанарын шаардлага хангахгүй болсон химийн бодис, урвалжийг 2022.12.11- ний өдөр “Элемент” ХХК ирж тээвэрлэн, Орон нутгийн хөрөнгө болох 2.736214.2 төгрөгөөр бүрэн устгал хийгдлээ.	100
10	Нийт хэрэгжилт		

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ТҮВШИНЖАРГАЛ

ХЭРЭГЖИЛТ ТООЦСОН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

ПЭРЭНЛЭЙМАА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХШҮДАХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ОДОНЧИМЭГ